In partnership with Canada | MERIT
A CESO AND WUSC PROGRAM

# Шалгуур үзүүлэлт:
# Шалгуур үзүүлэлт яагаад хэрэгтэй вэ?

Рэймонд Жирвэйс

2022

# Агуулга

- ❖ Тоон ба чанарын шалгуур үзүүлэлтүүдийг **тодруулах**
- ❖ Хэрхэн зөв/хүчтэй шалгуур үзүүлэлтийн тодорхойлолтыг боловсруулах вэ (бүтэц, шалгуур)
- ❖ Хүлээгдэж буй өөрчлөлтийн дагуу шалгуур үзүүлэлтийн төрлийг тодруулах
- ❖ Шалгуур үзүүлэлт ба зорилтот түвшний талаарх түгээмэл ташаа ойлголтууд

# Шалгуур үзүүлэлтийн тодорхойлолт

- Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт гэдэг нь бодит үр нөлөө, гарцыг хэмжих, үнэлэх арга юм. Шалгуур үзүүлэлт нь чанарын эсвэл тоон хэлбэртэй байж болох бөгөөд хэмжих нэгж, судлах нэгжтэй байна. Шалгуур үзүүлэлтүүд нь төвийг сахисан; өөрчлөлтийн чиглэл ба зорилтот түвшинг заадаггүй.

# Тоон болон чанарын шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт нь зорьж буй өөрчлөлт, зорилтот түвшнийг илэрхийлэхгүй, харин тэдгээрийг хэмжихэд ашиглана

| | Тоон шалгуур үзүүлэлт | Чанарын шалгуур үзүүлэлт |
|---|---|---|
| Юуг хэмжих вэ? | Аливаа зүйлийн тоо болон хэмжээг хэмжихэд хэрэглэдэг | Ажиглалт, сэтгэгдэл гэх мэт туршлагад суурилсан мэдээллийг чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжинэ (Аливаа зүйлийн чанар, нөхцөл байдлыг хүлээн авч буй сэтгэгдэл … )<br><br>Төлөв, дадал, арга аргачлал, нөхцөл байдлын мэдээллийг чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжинэ |
| Жишээ | • Нийт хүүхдийн тоо (эмэгтэй/эрэгтэй, насны бүлэг, хөдөө/хот) | • Төслийн хугацаанаас хойш хил дамнасан мөрдөн байцаалтыг үргэлжлүүлэхээр төлөвлөж буй орон нутгийн хараат бус сэтгүүлчдийн тоо (f/m) |
| | • Томуугийн эсрэг дархлаажуулалтад хамрагдсан нийт 6-15 насны (эмэгтэй/эрэгтэй ба хөдөө/хот) хүүхдийн хувь<br>• Засгийн газрын шийдвэр гаргах түвшинд байгаа эмэгтэйчүүдийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харьцаа | • Өөрийгөө ардчилсан засгийн газарт бүрэн буюу үндсэндээ оролцох чадвартай гэж үзсэн нийт хүмүүсийн хувь (эмэгтэй/м) |

Чанарын мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт хийх хүндрэлтэй байдаг учраас чанарын шалгуур үзүүлэлтийг боломжтой үед тоон хэлбэрт хөрвүүлж байх хэрэгтэй.
Жишээлбэл: итгэлтэй байдлыг 1-4 шатлалаар үнэлэх гэх мэт

# Сайн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн шинжүүд:

- ❖ **Оновчтой байдал**: Хэмжих ёстой зүйлээ хэмжиж байна уу?
- ❖ **Найдвартай байдал**: Цаг хугацааны явцад тогтвортой байх уу?
- ❖ **Мэдрэг байдал**: Өөрчлөлт гарсан тохиолдолд хэмжих боломжтой юу?
- ❖ **Хялбар байдал**: Мэдээлэл цуглуулахад хэр хялбар байх вэ?
- ❖ **Хэрэгцээтэй байдал**: Цуглуулсан мэдээлэл шийдвэр гаргахад хэрэг болох уу?
- ❖ **Хүртээмжтэй байдал**: Танд мэдээлэл цуглуулах нөөц боломж байгаа юу?

# Шалгуур үзүүлэлтээр хэмжих өөрчлөлтийн төрлүүд

Шалгуур үзүүлэлтийг ямар түвшний үр дүнг хэмжих гэж байгаагаар нь ангилж болно.

| Гарцын шалгуур үзүүлэлт | Богино хугацааны үр нөлөө / зорилт шалгуур үзүүлэлт | Дунд хугацааны үр нөлөө / зорилт шалгуур үзүүлэлт | Урт хугацааны үр нөлөө / зорилго шалгуур үзүүлэлт |
|---|---|---|---|
| Төслийн үйл ажиллагааны үр дүнд бий болох, хэрэгжүүлэгчээс зуучлагч эсвэл ашиг хүртэгчдэд хүргэх бүтээгдэхүүн, үйлчилгээг хэмжих. | Гарцын үр дүнд Хамтрагчид эсвэл ашиг хүртэгчдийн ур чадвар, мэдлэг, чадвар, мэдлэг, заримдаа хүртээмж зэрэг чадварын өөрчлөлтийг хэмжих. | Шууд үр нөлөөний үр дүнд Ашиг хүртэгч эсвэл хамтран ажиллагчдын Хандлага, зан төлөв, практик, гүйцэтгэлийн өөрчлөлт | Дунд хугацааны үр нөлөөний үр дүнд ашиг хүртэгчдийн амьдралд гарсан тогтвортой өөрчлөлтийг хэмжих. |
| - Зохион байгуулсан сургалтын тоо<br>- Сургалтын агуулгын ашиглахуйц байдалд өгсөн сурагчдын сэтгэл ханамж (эрэгтэй, эмэгтэй) | Сургалтад амжилттай хамрагдаж гэрчилгээ авсан эмч нарын тоо (эрэгтэй, эмэгтэй) | Үйлчлүүлэгчдэд жендэрийн мэдрэмжтэй эмчилгээ үзүүлж буй эмнэлгийн байгууллагын эзлэх хувь/нийт<br><br>(нийт эрүүл мэндийн байгууллагатай харьцуулах) | ... өвчлөлийн бууралтын хувь |

# Шалгуур үзүүлэлт ба зорилт

| Шалгуур үзүүлэлт | Зорилт |
|---|---|
| Шалгуур үзүүлэлт гэдэг нь бодит үр дүн, гарцыг хэмжихэд ашиглах багаж юм. Шалгуур үзүүлэлт нь тоон болон чанарын байж болох бөгөөд хэмжих нэгж, дүн шинжилгээ хийх нэгж байж болно. Шалгуур үзүүлэлт нь төвийг сахисан байх бөгөөд өөрчлөлт болон зорилтын чиглэлийг заадаггүй. | Зорилт нь үнэлгээ хийх хэмжээг зааж буй утга юм. Энэ нь шийдвэр гаргагчид гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг ашиглан ирээдүйд хүрэх хэмжээг харна. Шалгуур үзүүлэлтийг ашиглан зорилтыг хэмжин баталгаажуулснаар үр дүнгийн биелэлтийг тодорхойлох боломжтой. |

Шалгуур үзүүлэлтээр хэмждэг бол
хүрэхээр зорьж буй зүйлээр зорилгыг тодорхойлдог

Mongolia:
Enhancing Resource
Management through
Institutional Transformation

**Address:** Floor 3, National Times News Tower Khudaldaanii gudamj, Khoroo 1
Chingeltei district, Ulaanbaatar-15160 Mongolia

**Phone:** 7610-5000